# УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн бүс орчмын 19 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий ($SO_2$), азотын давхар исэл ($NO_2$), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон ($O_3$) болон цаг уурын үзүүлэлтүүдийг тасралтгүй хэмжилтийн автомат анализатораар тодорхойлж байна.

Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 8 мкг/$м^3$-ээр буюу 17 %-иар, хүхэрлэг хий ($SO_2$) 3 мкг/$м^3$-ээр буюу 50 %-иар тус тус бага, харин PM2.5 тоосонцор, азотын давхар исэл ($NO_2$) ижил түвшинд байна.

*Хүснэгт 1. Агаар дахь бохирдуулах бодисын 2025, 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламж*

| Бохирдуулах бодисын нэр | Сарын дундаж агууламж, мкг/$м^3$ | |
|---|---|---|
| | 2025 оны 08 дугаар сар | 2026 оны 08 дугаар сар |
| PM2.5 тоосонцор | 9 | 9 |
| PM10 тоосонцор | 46 | 38 |
| Хүхэрлэг хий, $SO_2$ | 6 | 3 |
| Азотын давхар исэл, $NO_2$ | 22 | 22 |

Улаанбаатар хотын 2026 оны 08 дугаар сарын агаар бохирдуулах бодис тус бүрийн сар, хоногийн дундаж агууламжийг дараах зурагт харууллаа. (Зураг 1-13)




*Зураг 1. 2025, 2026 оны 08 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламж*

***PM2.5 ТООСОНЦОР***




*Зураг 2. PM2.5 тоосонцрын 08 дугаар сарын агууламж, 2021-2026 он*

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламжыг 2021-2022 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-13 мкг/м$^3$-ээр буюу 18-59 %-иар бага, 2023 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 1 мкг/м$^3$-ээр буюу 12 %-иар их, 2024 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 1 мкг/м$^3$-ээр буюу 10 %-иар бага, 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай ижил түвшинд байна. (Зураг 2).




*Зураг 3. PM2.5 тоосонцрын 08 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр*

2026 оны 08 дугаар сарын PM2.5 тоосонцрын дундаж агууламж Амгалан 8 мкг/м$^3$, Баянхошуу 10 мкг/м$^3$ байна.

2025 оны 08 дугаар сартай харьцуулахад Мишээл экспо 4 мкг/м$^3$-ээр, Баруун 4 зам 4 мкг/м$^3$-ээр, 1-р хороолол 2 мкг/м$^3$-ээр, Цахилгаан станц 16 мкг/м$^3$-ээр, Ургах наран хороолол 2 мкг/м$^3$, Хайлааст 2 мкг/м$^3$-ээр, Шархад 2 мкг/м$^3$-ээр, Зурагт 2 мкг/м$^3$-ээр, бага, 100 айл, Яармаг, Нисэх ижил түвшинд, харин Налайх 1 мкг/м$^3$-ээр, Толгойт 16 мкг/м$^3$-ээр, Дамбадаржаа 3 мкг/м$^3$-ээр их байна (Зураг 3).




*Зураг 4. PM2.5 тоосонцрын 08 дугаар сарын хоногийн дундаж агууламж*

2026 оны 08 дугаар сарын PM2.5 тоосонцрын хоногийн дундаж агууламж 1-155 мкг/м$^3$ байсан байна. PM2.5 тоосонцрын хамгийн бага агууламж Хайлааст, Шархад, Налайх орчим 1 мкг/м$^3$, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 08 дугаар сарын 29-нд Толгойт орчим 155 мкг/м$^3$ буюу MNS 4585:2025 АЧС-аас 4.1 дахин их байсан байна (Зураг 4).

## ***PM10 ТООСОНЦОР***




*Зураг 5. PM10 тоосонцрын 08 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он*

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2024 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 3-14 мкг/м$^3$-ээр буюу 7-27 %-иар бага, 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжаас 8 мкг/м$^3$-ээр буюу 17 %-иар бага байна (Зураг 5).




*Зураг 6. PM10 тоосонцрын 08 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр*

2026 оны 08 дугаар сарын PM10 тоосонцрын дундаж агууламж Амгалан 31 мкг/м$^3$ байна.

Өмнөх оны мөн үе буюу 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад Баруун 4 зам 71 мкг/м$^3$-ээр, Бэхийн өргөө 5 мкг/м$^3$-ээр, Зурагт 11 мкг/м$^3$-ээр бага, 1-р хороолол ижил түвшинд, харин Мишээл экспо 3 мкг/м$^3$ -ээр, Хайлааст 20 мкг/м$^3$-ээр их, 5 буудал 5 мкг/м$^3$-ээр, Шархад 5 мкг/м$^3$-ээр, Налайх 6 мкг/м$^3$-ээр, Яармаг 2 мкг/м$^3$-ээр, Нисэх 2 мкг/м$^3$-ээр, Толгойт 15 мкг/м$^3$-ээр их байна. (Зураг 6).




*Зураг 7. PM10 тоосонцрын 08 дугаар сарын хоногийн дундаж агууламж*

2026 оны 08 дугаар сарын PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламж 1-167 мкг/м$^3$ байсан байна. PM10 тоосонцрын хамгийн бага агууламж Бэхийн өргөө орчим 1 мкг/м$^3$, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 08 дугаар сарын 29-нд Толгойт орчим 167 мкг/м$^3$ буюу MNS 4585:2025 АЧС-аас 1.6 дахин их байсан байна (Зураг 7).

## АЗОТЫН ДАВХАР ИСЭЛ ($NO_2$)




*Зураг 8. Азотын давхар ислийн 08 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он*

Азотын давхар ислийн ($NO_2$) 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2022 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-3 мкг/м$^3$-ээр буюу 8-12 %-иар бага, 2023 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2 мкг/м$^3$-ээр буюу 10 %-иар их, 2024 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 13 мкг/м$^3$-ээр буюу 37 %-иар бага, 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай ижил түвшинд байна (Зураг 8).




*Зураг 9. Азотын давхар ислийн 08 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр*

2026 оны 08 дугаар сарын азотын давхар исэл ($NO_2$)-ийн дундаж агууламж Амгалан 19 мкг/м$^3$ байна.

Өмнөх оны мөн үе буюу 2025 оны 08 дугаар сартай харьцуулахад Баруун 4 зам 6 мкг/м$^3$-ээр, 100 айл 4 мкг/м$^3$-ээр, Цахилгаан станц 7 мкг/м$^3$-ээр, Ургах наран хороолол 10 мкг/м$^3$-ээр, Хайлааст 3 мкг/м$^3$-ээр, 5 буудал 3 мкг/м$^3$-ээр, Налайх 12 мкг/м$^3$-ээр, Яармаг 13 мкг/м$^3$-ээр, Зурагт 5 мкг/м$^3$-ээр тус тус бага, харин Бөхийн өргөө 5 мкг/м$^3$-ээр их, Зайсан 21 мкг/м$^3$-ээр, Шархад 6 мкг/м$^3$-ээр, Толгойт 2 мкг/м$^3$-ээр их байна (Зураг 9).




*Зураг 10. Азотын давхар ислийн 08 дугаар сарын хоногийн дундаж агууламж*

2026 оны 08 дугаар сарын азотын давхар исэл ($NO_2$)-ийн хоногийн дундаж агууламж 4-61 мкг/м$^3$ байсан байна. Азотын давхар исэл ($NO_2$)-ийн хамгийн бага агууламж нь 100 айл орчим 4 мкг/м$^3$, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 08 дугаар сарын 09-нд Зайсан орчим 61 мкг/м$^3$ буюу MNS 4585:2025 АЧС-аас 1.2 дахин их байсан байна (Зураг 10).

## ***<u>ХҮХЭРЛЭГ ХИЙ ($SO_2$)</u>***




*Зураг 11. Хүхэрлэг хийн 08 дугаар сарын дундаж агууламж, 2021-2026 он*

Агаар дахь хүхэрлэг хийн ($SO_2$) 2026 оны 08 дугаар сарын дундаж агууламжийг 2021-2024 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 2-6 мкг/м$^3$-ээр буюу 40-67 %-иар бага, өмнөх оны мөн үе буюу 2025 оны 08 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 3 мкг/м$^3$-ээр буюу 50 %-иар бага байна (Зураг 11).




*Зураг 12. Хүхэрлэг хийн 08 дугаар сарын дундаж агууламж агаарын чанарын станц тус бүрээр*

2026 оны 08 дугаар сарын хүхэрлэг хий ($SO_2$)-н дундаж агууламжийг 2025 оны 08 дугаар сартай харьцуулахад 1-р хороолол 2 мкг/м$^3$-ээр, 100 айл 1 мкг/м$^3$-ээр, Ургах наран хороолол 5 мкг/м$^3$-ээр, 5 буудал 2 мкг/м$^3$-ээр, Налайх 2 мкг/м$^3$-ээр, Яармаг 7 мкг/м$^3$-ээр, Толгойт 3 мкг/м$^3$-ээр тус тус бага, харин Баруун 4 зам, Бөхийн өргөө, Цахилгаан станц, Хайлааст, Шархад ижил түвшинд байсан байна (Зураг 12).




*Зураг 13. Хүхэрлэг хийн 08 дугаар сарын хоногийн дундаж агууламж*

2026 оны 08 дугаар сарын хүхэрлэг хийн ($SO_2$) хоногийн дундаж агууламж 1-22 мкг/м$^3$ байсан байна. Хүхэрлэг хийн ($SO_2$) хамгийн бага агууламж нь 1-р хороолол, 100 айл, Цахилгаан станц, 5 буудал, Шархад, Налайх, Толгойт орчим 1 мкг/м$^3$, харин хамгийн өндөр агууламж илэрсэн цэг 08 дугаар сарын 21-нд Толгойт орчим 22 мкг/м$^3$ хүрсэн боловч MNS 4585:2025 АЧС-аас даваагүй байна (Зураг 13).


УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН ХҮХЭРЛЭГ ХИЙН (SO2) ДУНДАЖ АГУУЛАМЖ
Сонгино Хайрхан
Сүхбаатар
Чингэлтэй
Баянзүрх
Хан-Уул
Налайх
Баянхошуу
Толгойт
Зурагт
Хайлааст
100-н айл
Шархад
Бөхийн өргөө
Цахилгаан станц
Зайсан
Яармаг
Нисэх
Ургах наран хор
Налайх
Дүүргийн хил
Агаарын чанарын автомат харуул
Агуулмаж мкг/м3
<= 10
10 - 20
20 - 30
30 - 50
50 - 70
70 - 100
100 - 120
120 - 150
150 - 170
> 170
0
5
10 км
Мэдээллийн эх үүсвэр: ЦУОШГ


УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН (NO2) ДУНДАЖ АГУУЛАМЖ
Сонгино Хайрхан
Сүхбаатар
Чингэлтэй
Баянзүрх
Хан-Уул
Налайх
Баянхошуу
Толгойт
Зурагт
Хайлааст
100-н айл
Шархад
Амгалан
Цахилгаан станц
Зайсан
Яармаг
Нисэх
Ургах наран хор
Налайх
Дүүргийн хил
Агаарын чанарын автомат харуул
Агуулмаж мкг/м3
<= 10
10 - 20
20 - 30
30 - 50
50 - 70
70 - 100
100 - 120
120 - 150
150 - 170
> 170
0
5
10 км
Мэдээллийн эх үүсвэр: ЦУОШГ



УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН PM10 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ
Сонгино Хайрхан
Сүхбаатар
Чингэлтэй
Баянзүрх
Хан-Уул
Налайх
Баянхошуу
Толгойт
Зураг
Хайлааст
100-н айл
Шархад
Бөхийн өргөө
Цахилгаан станц
Зайсан
Яармаг
Нисэх
Уурах наран хор
Налайх
Дүүргийн хил
Агаарын чанарын автомат харуул
Агуулмаж мкг/м3
<= 10
10 - 20
20 - 30
30 - 50
50 - 70
70 - 100
100 - 120
120 - 150
150 - 170
> 170
0
5
10 км
Мэдээллийн эх үүсвэр: ЦУОШГ




УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН PM2.5 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ
Сонгино Хайрхан
Сүхбаатар
Чингэлтэй
Баянзүрх
Хан-Уул
Налайх
Баянхошуу
Толгойт
Зураг
Хайлааст
100-н айл
Шархад
Бөхийн өргөө
Цахилгаан станц
Зайсан
Яармаг
Нисэх
Уурах наран хор
Налайх
Дүүргийн хил
Агаарын чанарын автомат харуул
Агуулмаж мкг/м3
<= 10
10 - 20
20 - 30
30 - 50
50 - 70
70 - 100
100 - 120
120 - 150
150 - 170
> 170
0
5
10 км
Мэдээллийн эх үүсвэр: ЦУОШГ

## 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКС, /АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАНЦ ТУС БҮРЭЭР ҮЗҮҮЛЭВ/




## УЛААНБААТАР ХОТЫН 2026 ОНЫ 08 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ /2025 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАВ/

| № | Цаг уурын үзүүлэлт | 2025 оны 08 дугаар сарын дундаж | 2026 оны 08 дугаар сарын дундаж | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Агаарын дундаж температур˚С | 16.5 ˚С | 17.5 ˚С | 1.0˚С-аар их |
| 2 | Салхины дундаж хурд, м/с | 2.4 м/с | 2.3 м/с | 0.1 м/с-ээр бага салхитай |
| 3 | Сарын нийлбэр хур тунадас, мм | 101 мм | 51 мм | 51 мм хур тунадастай |

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**